



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20²⁴ он ⁰³ дугаар
сарын ⁰⁹ ны өдөр

Дугаар *208/580*

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН
С.БЯМБАЦОГТ ТАНАА

Асуулгын хариу хүргүүлэх тухай

"Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай"
Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн 92 дугаар тогтоолын
хэрэгжилтийн талаар Монгол Улсын Ерөнхий сайдад тавьсан асуулгын хариуг
Танд хүргүүлж байна.

Хүлээн авч, танилцана уу.

Хавсралт: *29* хуудастай.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН С.БЯМБАЦОГТ НАРЫН ГИШҮҮДЭЭС
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДАД ТАВЬСАН АСУУЛГЫН ХАРИУ

Асуулга 1. Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр баталсан “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг заалт тус бүрээр гаргаж ирүүлэх:

Нэг. Тогтоолын 1.1-т: “Монгол Улсын Засгийн газар болон Айвенхоу майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу майнз Лтд, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд компани хооронд 2009 оны 10 дугаар сарын 06-ны өдөр байгуулсан Хөрөнгө оруулалтын гэрээ, Эрдэнэс Монгол ХХК болон Айвенхоу Оюу Толгой (Ви Ви Ай) Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, “Оюу Толгой” ХХК (ОТ ХХК) хооронд 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан Хувь нийлүүлэгчдийн гэрээ (нэмэлт, өөрчлөлт оруулж дахин тодотгосон)-ний хэрэгжилтийг Улсын Их Хурлын 2008 оны “Үндсэн зарчим, удирдамж батлах тухай” 40 дүгээр тогтоол, 2009 оны “Оюу толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний тухай” 57 дугаар тогтоол болон Монгол Улсын хууль тогтоомжтой уялдуулан сайжруулах чиглэлээр цогц арга хэмжээ авах, шаардлагатай тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус зөвлөх үйлчилгээ авах.” гэсний хүрээнд:

1. Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн “Ажлын хэсэг байгуулах тухай” 174 дүгээр захирамжаар “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, Оюу толгой төслийн гадны хөрөнгө оруулагч талтай хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан. Уг Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 2 дугаар сарын 9-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчлэн байгуулаад байна.

2. “Төлөвлөгөө батлах тухай” Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 74 дүгээр тогтоолын 1 дэх заалтаар “Оюу Толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах “Ажлын ерөнхий төлөвлөгөөг” батлаад байна.

3. Улмаар дээрх Ажлын хэсгийн дарга, Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 23 дугаар тушаалаар “Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр батлагдсан 92 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангах хүрээнд Монгол Улсын Ерөнхий сайдын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 174 дүгээр захирамжийн дагуу байгуулагдсан Ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, зохицуулах үүрэг бүхий Ажлын дэд хэсгийг Санхүүгийн асуудал хариуцсан, Хуулийн асуудал хариуцсан, Техникийн хамтарсан хэсэгтэйгээр байгуулж, тэдгээрийн ажиллах чиглэлийг зааж өгсөн.

4.Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар захирамжаар шинэчлэн байгуулагдсан Ажлын хэсэг 3 дахь удаагаа хуралдаад байгаа бөгөөд Ажлын хэсгий эхний хуралдаан 2021 оны 2 дугаар сарын 18-ны өдөр цахим хэлбэрээр болж, түүгээр Ажлын хэсгийн ажиллах журам, мэдээлэл сонсох дарааллыг тогтоосон болно.

Ажлын хэсгийн 2 дахь удаагийн хуралдааныг 2021 оны 2 дугаар сарын 20-ны өдөр Хууль зүй, дотоод хэргийн яамны хурлын танхимд зохион байгуулж, уг хуралдаанаар “Эрдэнэс Оюу Толгой” ХХК-ийн бэлтгэсэн Оюу толгой төслийн явц байдал, түүнд холбогдох гэрээнүүдийн хэрэгжилт, төслийн санхүүжилт, Монгол Улсад өгөх өгөөж, төслийн геологи-уул уурхайн явц байдал, ашиглалтын тусгай зөвшөөрөл бүхий талбайн танилцуулга-тайлбартай сонсож, Ажлын хэсгийн гишүүд асуулт асууж, хариулт авч, санал солилцсон.

Ажлын хэсгийн 3 дахь удаагийн хуралдаан 2021 оны 2 дугаар сарын 23-ны өдөр Төрийн ордонд зохион байгуулж, уг хуралдаанаар Улсын Их Хурлын гишүүн Г.Тэмүүлэнгийн боловсруулж, бэлтгэсэн Оюу Толгой төслийн хөрөнгө оруулалтын болон бусад гэрээний тухай мэдээлэл, Татварын ерөнхий газраас боловсруулж, бэлтгэсэн Оюутолгой ХХК-д хийсэн татварын хяналт шалгалт, Мэргэжлийн хяналтын ерөнхий газраас боловсруулж, бэлтгэсэн Оюу Толгойн бүлэг ордоос олборлон борлуулж байгаа баяжмалд агуулагдаж буй молибденийн асуудал зэрэг мэдээллийг сонсож, Ажлын хэсгийн гишүүд асуулт асууж, хариулт авч, санал хэлсэн болно. Түүнчлэн, уг хуралдаанд Монгол Улсын Ерөнхий сайд оролцож, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, сайжруулах чиглэлд баримтлах зарчим, анхаарах асуудал, ажиллах арга журмын талаар байр сууриа илэрхийлж, Ажлын хэсэгт багтсан зарим Улсын Их Хурлын гишүүдийн асуултад хариулж, санал бодлыг нь сонссон.

Мөн хуралдаанд Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолын 1.1 дэх хэсэгт “шаардлагатай тохиолдолд олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн хараат бус зөвлөх үйлчилгээ авах”-аар заасны дагуу гэсэн зөвлөх үйлчилгээ авах төндөр шалгаруулалт зарлагдаж байгаа талаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга Б.Солонгоо товч танилцуулсан.

Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 3 дугаар сарын 31-ний өдрийн 23 дугаар тушаалаар байгуулагдсан Ажлын дэд хэсэг тус бүр ажиллах чиглэлийнхээ хүрээнд зохих мэдээлэл, судалгаа, тооцоололд үндэслэн дараах санал, дүгнэлтийг урьдчилсан байдлаар боловсруулж, Ажлын дэд хэсэгт танилцуулсан. Үүнд:

1/ Хуулийн асуудал хариуцсан ажлын дэд хэсгийн хүрээнд:

Төслийн өгөөжийн талаар:

-Монгол Улсын Үндсэн Хуулийн Зургаадугаар зүйлийн 2-т тусгагдсан “үр өгөөж” гэдэг ойлголтыг ердийн хуулиар тодорхойлох, энэ талаарх хуулийн төслийг холбогдох яам нь яаралтай боловсруулж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

-хөрөнгө оруулагч талтай гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг шийдвэрлэх.

Татварын орчны талаар:

-Оюутолгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээ (ХӨОГ)-ний үйлчлэлд Оюу толгой Нидерланд БиВи, Ти Эйч Ар Оюу толгой БиВиАй нараас гадна түүний хамааралтай этгээд, гэрээт гүйцэтгэгч, туслан гүйцэтгэгч нарыг хамруулж энэ гэрээний ашиг тусыг хэт олон субъектэд эдлүүлэхээр байгааг хязгаарлах;

-“татварын орчин” гэх нэр томъёог нарийвчлан тодорхойлох, энэ талаар ХӨОГ-нд тусгах.

Гэрээний хэрэгжилттэй холбоотой маргаан шийдвэрлэх талаар:

-арбитрт дуудагдахын өмнө Монгол Улс зарим шийдвэрээ эргэн харах нөхцөл бүрдүүлэх үүднээс ХӨОГ-ний маргаан шийдвэрлэх бүлэгт Монгол Улсын хууль тогтоомжид заасан урьдчилан шийдвэрлэх ажиллагааг зохих журмын дагуу хийлгэсний дараа Лондонгийн Олон улсын арбитрын шүүхэд ханддаг байх талаар тохиролцох.

Антре гоулд компанийн талаар:

-“Антре гоулд” ХХК-ийн эзэмшилд буй лицензийн талбай нь Оюу Толгой бүлэг ордод хамаарах эсэхийг Засгийн газар ордын хил, заагийг тогтоож, эцэслэн шийдвэрлэх;

-“Антре гоулд” ХХК-ийн ТЭЗҮ-д үндэслэн Засгийн газарт ашигтай хувилбарыг тооцоолж, Антре Гоулд ХХК, ОТ ХХК нартай хэлэлцээрийг дараахь хувилбаруудаар хийх:

1.“Антре гоулд” ХХК-ийн хувьцаанаас Засгийн газар эзэмшиж, тус талбайг ХӨОГ-нд хамааруулах эсэх (хувьцаанд ногдох хөрөнгө оруулалтыг хийж, ногдол ашиг, тогтворжуулсан татвар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр (АМНАТ) авах);

2.хувьцаа эзэмшихгүй, ХӨОГ-нд хамааруулахгүйгээр албан татвар, АМНАТ зэргийг одоогийн хуульд заасан хэмжээгээр авах;

3.бусад оновчтой хувилбарыг боловсруулах зэрэг болно.

Бусад асуудлын талаар:

-“бүтээгдэхүүн” гэх тодорхойлолтыг ХӨОГ болон бусад гэрээнд өөрөөр тодорхойлсныг нэг мөр болгох;

-техник, эдийн засгийн үндэслэл (ТЭЗҮ) дэх зардал, түүний хэлбэлзэлд зохих хязгаар тогтоох;

-менежментийн үйлчилгээний төлбөрийг тогтооходоо суурь зардалд үндэслэж байгааг өөрчлөх;

-сонирхлын зөрчилтэй хэлцэлд Компанийн тухай хуулийн зохицуулалтыг хэрэглэх өөрчлөлтийг зохих гэрээнд тусгах зэрэг урьдчилсан санал, дүгнэлт гараад байна.

2/ Санхүүгийн асуудал хариуцсан ажлын дэд хэсгийн хүрээнд:

Санхүүгийн асуудал хариуцсан ажлын дэд хэсгийн хүрээнд дараахь асуудлуудыг хэлэлцэж, түүнд холбогдох зохих саналуудыг урьдчилсан байдлаар гаргасан бөгөөд эцэслэсэн хувилбарыг тогтоогүй байна. Тэдгээрт тухайлбал,

Хувь нийлүүлэгчдийн болон санхүүжилтийн зээлийн хүүгийн талаар:

Хөрөнгө оруулалтын гэрээний 2.31-д "Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3-т заасан зээл, хөрөнгө оруулалтын харилцааг дараахь байдлаар тооцно:

-гэрээний 2.31.1-д хөрөнгө оруулагчийн авсан зээл, хөрөнгө оруулалтын харьцаа 3:1-ээс илүү..." гэж заасны дагуу Хувьцааны санхүүжилт 25% Хувь нийлүүлэгчдийн зээлээр 75%-ийг санхүүжүүлж ирсэн.

-нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээ (НӨОДТХНГ)-ний 13.1-д "Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид нь ... Хувь нийлүүлэгчдийн авах зээлийн хэлбэрээр санхүүжилт хийхээр шийдвэрлэсэн тохиолдолд ТӨК түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нийлүүлэх шийдвэр гаргаж болно (гэвч ингэх үүрэг хүлээхгүй);

-хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид энэ хугацаанд ийм шийдвэр гаргаагүй бол энэхүү Гэрээний 10.2(а)-д заасны дагуу түүнээс Шаардсан мөнгөн хөрөнгийг бүхэлд нь нийлүүлэхээр шийдвэрлэсэнд тооцогдоно." гэж заасан байдаг.

Цаашид Оюу Толгой (ОТ) төслийн хувь эзэмшигч талууд (цаашид Талууд гэх) хооронд 2011 оны 6 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан Нэмэлт, өөрчлөлт оруулж, дахин тодотгосон Хувь нийлүүлэгчдийн гэрээний 11.3. (ё) 1 дэх заалтын дагуу Оюутолгой төслийн Хувь нийлүүлэгчдийн гэрээний хүрээнд Санхүүжилтийн болон Хувь нийлүүлэгчийн зээлийн **хүүгийн зохистой түвшин** гэдэгт дараах асуудлыг заавал гэрээнд оруулж шийдвэрлэх. Үүнд:

1. OECD үнэ шилжилтийн зарчим болон, S&P, Moody's зэрэг олон улсын нэр хүнд бүхий **зээлжих зэрэглэл тогтоодог** байгууллагын гаргасан аргачлал баримтлах;
2. Standard&Poor's-ийн "Групп компанийн үнэлгээний аргачлал"-ын дагуу толгой компанийн **"шууд бус дэмжлэг"**- нэр томъёоны хүрээг гаргах нарийвчлан гаргах журамлах;
3. хувь нийлүүлэгчийн зээлийн шинж чанарыг гэрээнд өөрчлөлт орохоос өмнө талууд тохиролцох;

4. Хувь нийлүүлэгчдийн зээл болон санхүүжилтийн хүүд хугацааны нөлөөллөөс шалтгаалан талуудын дунд хүүгийн хувийг өөр өөрөөр тогтоох нөхцөл бий болоод байх тул журам гаргах;
5. Дээрх журмууд бий болсноор хувь нийлүүлэгчдийн зээл болон санхүүжилтийн хүүгийн хувийг өөрчлөх боломж бүрдэх юм.

Менежментийн зардалд тавих нөхцөлүүдийн талаар:

Менежментийн үйлчилгээний төлбөрийн харилцааг ХөОГ, НӨОДТХНГ болон Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө (ДУББСТ), Далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө (ДУББСНТ) зэрэг бичиг баримтын хүрээнд зохицуулж байна. 2010 онд ХөОГ болон НӨОДТХНГ байгуулж байх үед Менежментийн үйлчилгээний төлбөрийг дараах байдлаар тогтоож төлөхөөр зохицуулсан байдаг. Үүнд: НӨОДТХНГ-ний 7.4(а) заалтад "Компани нь Менежментийн багт Менежментийн үйлчилгээний төлбөрийг төлнө"; 7.2(в) заалтад "Гүйцэтгэх удирдлага Компанийн өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулахад Менежментийн багаас үзүүлэх үйлчилгээ, туслалцаа нь инженеринг, үйл ажиллагаа, төлөвлөлт болон үнэлгээ, байгаль орчин, маркетинг, ханган нийлүүлэлт, хууль зүй, худалдаа, төлбөр тооцоо, санхүүгийн үйлчилгээ, түүнчлэн Үндсэн үйл ажиллагааг үр дүнтэй зохион байгуулахад шаардлагатай гэж үзсэн бусад бүхий л үйлчилгээнээс бүрдэж болно." гэжээ.

Менежментийн үйлчилгээний төлбөрийн хэмжээг НӨОДТХНГ-ний 7.4(в) заалтад:

(i) Гэрээ хүчин төгөлдөр болох өдрөөс эхлэн Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдөр хүртэлх хугацаанд тухайн хугацаанд гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 3 (гурван) хувь;"

(ii) Үйлдвэрлэлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс хойших хугацаанд гарсан Үндсэн хөрөнгийн зардал болон Үйл ажиллагааны зардлын нийт дүнгийн 6 (зургаан) хувь байна."

гэж тусгасан байдаг. Хөрөнгө оруулагч тал болох Рио Тинто компани нь дээр дурдсан менежментийн үйлчилгээний төлбөрөөс гадна Рио Тинто группийн үйлчилгээний төлбөр (Стратегийн болон Үйл ажиллагааны) гэгдэх нэмэлт төлбөрийг ногдуулж байна.

Менежментийн үйлчилгээний төлбөр тооцох суурийг тогтоохдоо дараахь нөхцөлийг бий болгох нь зүйтэй гэж үзсэн:

-Компанийн менежментийн төлбөр ногдуулахдаа гүйцэтгэлийн чанар, хугацаа, төсөвлөсөн хөрөнгийн хэтрэлт хэмнэлт зэрэг хэмжигдэхүйц бусад үзүүлэлтийг суурь болгох;

-Гэрээнд харилцан хамааралгүй хуулийн этгээдийн хооронд хийгдсэн адил төрлийн бараа, ажил, үйлчилгээний зах зээлийн үнийг жишиг болгох, бүлгийг нэмж оруулах ба дараахь асуудлыг заавал тусгах. Үүнд:

-хамааралтай хэлцлийг тодорхойлохдоо "зах зээлийн өрсөлдөхүйц үнээр харилцан хамааралгүй этгээдүүдийн хооронд тохиролцох арилжааны нөхцөл гэдгийг гол суурь болгох авч үзэх;

-менежментийн үйлчилгээг бодит байдлаар үзүүлсэн эсэхийг хянаж үзэх, улмаар гүйцэтгэлийн тайланг дэлгэрэнгүй байдлаар гаргадаг байх журмыг баталгаажуулах;

-эдийн засаг, хамтын ажиллагааны байгууллагаас (OECD) батлан гаргасан "Сунгасан гарын зарчим" (BEPS-ийн нөхцөл) -ын дагуу Групп компанийн гишүүн нэг компаниас нөгөө гишүүн компанид Менежментийн үйлчилгээ үзүүлсэн бол уг үйлчилгээг хүлээн авагч компани нь тодорхой "үр өгөөж"/benefit хүртсэн байх ёстой гэсэн шалгуурын үзүүлэлтийг гаргах, тайлан гаргадаг тогтолцоог бий болгох загвар маягыг журамлах зэрэг санал гарчээ.

Түүнчлэн, төсөл хэрэгжүүлэгч компани нь өгөөж буюу benefit хүртсэн нь нотлогдохгүй дараахь үйлчилгээнд Менежментийн төлбөр ногдуулахгүй байх талаар хэлэлцсэн бөгөөд үүнд:

- хувь нийлүүлэгчийн үйлчилгээнүүд – Эдгээр үйлчилгээнүүд нь үйлчилгээ хүлээн авагчийн эрх ашгийн төлөө бус Хувь нийлүүлэгчид өөрсдийнхөө эрх ашгийн төлөө үзүүлж буй үйлчилгээнүүд;
- дагалдах үр өгөөж – Групп компанид харьяалагддагийн хувьд Хувь нийлүүлэгчдээс ямар нэгэн тодорхой үйл ажиллагаа явуулаагүй урьдчилгаа төлбөр төлсөн үйлчилгээ;
- давхардах үйл ажиллагаанууд – Уг үйлчилгээг хүлээн авагч нь өөрөө хэдийн хийж гүйцэтгэсэн үйлчилгээнүүд бөгөөд үйлчилгээг хүлээн авагч нь ямар нэгэн үр өгөөж хүртдэггүй үйл ажиллагаанууд болно.

Монгол Улсын татварын хуулийн нөхцөлийг бүрэн хангасан татварын ногдол хийгдсэн ажил гүйлгээ байх гэсэн заалтыг нарийвчлан тодорхойлох шаардлагатай.

Баталгааны шимтгэлийн талаар:

2015 оны 5 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан "Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөөний 5.5 (v)-д "ОТ ХХК-иас нэхэмжлэх Төслийн санхүүжилтийн баталгааны шимтгэл нь Далд уурхайн Төслийн санхүүжилтийн үндсэн дүн, хүү, шимтгэл, төлбөрийн тухайн үеийн үлдэгдлийн 1,9%-иас хэтрэхгүй байхыг Туркойз Хилл болон Рио Тинто зөвшөөрч байна" гэж заасан байдаг. Улмаар "Төслийн санхүүжилт"-ийн хүрээнд 2015 оны 12 дугаар сарын 15-ны өдөр нэг талаас "Оюутолгой" ХХК, нөгөө талаас "Туркойз Хилл Ресурс Лимитед" болон "Рио Тинто ПиЭлСи" компанийн хооронд байгуулсан "Санхүүжилтэд дэмжлэг үзүүлэх тухай гэрээ" -ээр санхүүжилтийн баталгаатай холбоотой бүхий нөхцөлийг нарийвчлан зааж өгсөн. Тэдгээрт:

1. Оюутолгой төсөл нь Монголын хувьд стратегийн чухал төсөл бөгөөд Монголын засгийн газрын юуны түрүүнд барих эхний байр суурь нь чухал түнш болох Рио Тинтотой хамтран төслийг үргэлжлүүлэх ба Хөрөнгө оруулалтын гэрээ, Нэмэлт

өөрчлөлт оруулж дахин тодотгосон хувь нийлүүлэгчдийн гэрээний бүхий л заалт нөхцөлийг хүндэтгэн авч үзэж байгаагаа илэрхийлэх. Рио Тинтогийн зүгээс ОТ төслийг санхүүжүүлэх үүргийг хүлээсэн.

2. Засгийн газрын байр сууринаас харахад уг төсөл нь Засгийн газарт таатай нөхцөл болох төслөөс олох эдийн засгийн үр ашгийн 53:47 харьцаагаар хуваана хэмээн ТЭЗҮ-гээр заасан таамаглалд суурилсан. Засгийн газрын хувьд санаа зовж байгаа зүйл бол Засгийн газрын хувьд татвар, ногдол ашиг, нөөц ашигласны төлбөр, Рио Тинтогийн зүгээс хүү, менежментийн үйлчилгээний төлбөр, ногдол ашиг, баталгааны төлбөр зэрэгтэй харьцуулан авч үзэхэд одоогийн байгаа тооцооллоор дээрх нөхцөл биелэх боломжгүй болсон бөгөөд үүнтэй холбогдуулан Монголын Засгийн газар Рио Тинто санхүүгийн баталгааны төлбөрийг хамааралтай хэлцэлд тооцох цаашид дараахь асуудлыг хөндөх шаардлагатай байна:

- a. Хөрөнгө оруулагч зээлжих зэрэглэлийн дагуу сунгасан гарын зарчмын хүрээний хувь хэмжээг мөн дээр дурдсаны дагуу мэдээллийн баазаас гарсан үзүүлэлтийн хамгийн бага баталгааны хувийг сонгохыг гэрээнд тусгайлан заах;
- b. Монгол Улсын Татварын хуулийн нөхцөлийг бүрэн хангасан татварын ногдол хийгдсэн ажил гүйлгээ байна;
- c. Санхүүгийн баталгааны implicit, explicit хэсгийг нь ялгаж, зөвхөн explicit хэсэг дээр нь төлбөр төлөх талаар судалгаа нь дараахь зарчмуудад үндэслэнэ:
 - o Санхүүгийн баталгааны хувь хэмжээний 'зохистой түвшин'-г тодорхойлохын тухайд OECD (Эдийн засгийн хамтын ажиллагаа, хөгжлийн байгууллага ЭЗХАХБ)-ийн сунгасан гарын зарчмын аргачлал болон бусад олон улсын стандартууд чухал суурь болгох;
 - o S&P CreditModel-ийг ашиглан ОТ ХХК-ийн "бие даасан" зээлжих зэрэглэлийг тогтоох;
 - o төслийн санхүүжилтийн зээлийн хувь хэмжээ нь хамааралгүй этгээдүүдийн хооронд хийгдсэн учраас сунгасан гарын зарчимд нийцсэн хувь хэмжээ гэж үзэх;
 - o томоохон гурван зээлжих зэрэглэл тогтоогч агентлагаас хэвлэн нийтэлсэн журамд шууд бус дэмжлэгийг хэрхэн хамааруулан авч үзэх талаар тусгайлсан аргачлалыг гаргах. Үүнд:
 - группийн зээлжих зэрэглэл тогтоох;
 - баталгаа гаргаагүй охин компаниудын зээлжих зэрэглэл харгалзах зээлийн үзүүлэлтүүдийг бий болгох;
 - фитч зээлжих зэрэглэл тогтоох;
 - эдийн Засгийн Хамтын Ажиллагаа, Хөгжлийн Байгууллагын Үндэстэн Дамнасан Корпорацууд (ҮДК) ба Татварын Байгууллагуудын Үнэ Шилжилтийн журмыг үндэслэх;

-зээлжих зэрэглэлийг олон улсын үнэ шилжилтийн мэдээллийн баазаас гаргаж буй Loan Connector болон TP Catalyst зэрэг бусад мэдээллийн баазын суурыг үндэслэл болгох нөхцөлийг бүрдүүлэх зэрэг асуудлыг тусгах шаардлагатай байна.

Талуудад хуваарилах ногдол ашгийн асуудлын талаар:

НӨОДТХНГ-ний 14 (а) Хэрэв тухайн Санхүүгийн жилд Компани нь Ногдол ашиг хуваарилахаар ашигтай ажилласан бол ТУЗ нь тэрхүү ашгийн 100 (нэг зуу)-аас доошгүй хувийг тус Санхүүгийн жил дууссанаас хойш 3 (гурван) сарын дотор мөнгөн хэлбэрээр Ногдол ашиг болгон хуваарилахаар зарлана. Ийнхүү зарлахдаа уг гэрээний 15.1(г), 15.2(в), түүнчлэн энэхүү гэрээний 14-т заасан Төслийн санхүүжилтийг гуравдагч этгээдээс авсан нөхцөлийн дагуу хүлээсэн үүргийг тус тус харгалзан энэхүү Гэрээний 15-д заасан бусад заалтыг баримтална. Ийнхүү хуваарилахдаа, Компанийн ирээдүйн бэлэн мөнгөний хэрэгцээ (үүнд, болзошгүй өргөтгөлийн зардал, эргэлтийн болон үндсэн хөрөнгийн зардал, бусад бодит болон нөхцөлт өр төлбөрт шаардагдах хөрөнгө)-г хангахад хүрэлцэхүйц зохистой хэмжээний нөөц авч үлдэнэ.

Мөн гэрээний 14 (г) Энэхүү Гэрээний бусад заалтаас үл хамааран Компани нь дараах үүргүүдийг дор дурдсан дарааллаар биелүүлээгүй тохиолдолд болон биелүүлж дуусах хүртэл Ногдол ашиг (энгийн хувьцаанд) хуваарилахгүй. Үүнд:

- (i) энэхүү Гэрээний 14-т заасан гуравдагч этгээдийн Төслийн санхүүжилтийг тухайн гуравдагч этгээдийн шаардсаны дагуу эхний элжинд буцаан төлөх;
 - (ii) Хувь нийлүүлэгчийн одоогийн зээлийг Компани бүрэн төлсөн байх;
 - (iii) энэхүү Гэрээний 13-т заасан Хувь нийлүүлэгчийн өрд тооцох аливаа хүү болон Санхүүжүүлэх хувьцаанд (тэдгээрийг энэхүү Гэрээний 12-т заасны дагуу Хувьцаанд хөрвүүлээгүй бол) ногдох бүх ногдол ашгийг Компани бүрэн төлсөн байх (дараалал нь нэг байна);
 - (iv) Энэхүү Гэрээний 13-т заасан Хувь нийлүүлэгчийн өрийн бүх үндсэн өрийг Компани бүрэн буцаан төлсөн байх болон бүх Санхүүжүүлэх хувьцаа (тэдгээрийг энэхүү Гэрээний 12-т заасны дагуу Хувьцаанд хөрвүүлээгүй бол)-ны хөрөнгийг Компани эргүүлэн авсан байх (дараалал нь нэг байна);
 - (v) давуу эрхийн хувьцаанд ногдох (Санхүүжүүлэх хувьцаанаас бусад) бүх ногдол ашгийг Компани бүрэн төлсөн байх, мөн давуу эрхийн нийт хувьцааг (Санхүүжүүлэх хувьцаанаас бусад) Компани эргүүлэн авсан байх
- аар тус тус заасан байдаг. Үүнд нөхцөл байдлын судалгаа хийхэд дараахь байдалтай болоод байгаа. Тухайлбал:

1. Санхүүжилтийн бүтэц ялангуяа хувь нийлүүлэгчдийн зээлийн хүүгийн зардал нь Монголын талын хүртэх өгөөжид шууд нөлөөлж байна. Өөрөөр хэлбэл, Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (ААНОАТ)-ын тайлангаар тайлагнасан алдагдал болон ногдол ашиг нь урвуу хамааралтай судалгаа гарсан байгаа. Энэ нь гадаадын хөрөнгө оруулагч тал зардал өсгөж, төслийг ашиггүй ажиллуулж, зээлээр санхүүжүүлж ашгаа хүртэх хандлагатай байгаа бол Монголын тал төслийг ашигтай ажиллах нөхцөлд ашиг хүртэхээр байна;

2. Чөлөөт мөнгөн хөрөнгийн үлдэгдэл нь хувь нийлүүлэгчдийн зээл, түүний хүүгийн төлбөрт зарцуулагдаж байна. Энэ нь хөрөнгө оруулалт хийх,

ногдол ашиг тараах нөхцөлийг хааж байна. Ингэснээрээ ААНОАТ(25%) төлөх хугацааг хойшлуулж, мөнгөн дүнг бууруулж байна. Мөн ногдол ашиг хуваарилах хугацааг хойшлуулж, мөнгөн дүнг бууруулж байна. Ногдол ашиг хуваарилах хугацаа хойшлогдох тутам Монголын талын Үлдэгдэл төлбөрт хүү тооцох хугацаа нэмэгдэж, ногдол ашгаараа Үлдэгдэл төлбөрөө төлж барахгүй нөхцөл үүснэ. Цаашид:

- ногдол ашиг хуваарилах нөхцөлийг үйл ажиллагааны мөнгөн гүйлгээний тайлантай холбож үзэх;
- талуудыг хооронд ногдол ашиг хуваарилах тайлангийн журмыг боловсруулах, гаргах, мөрдүүлэх шаардлагатай ба энэ нь стратегийн хөрөнгө оруулагчийг ашигтай ажиллуулахад чиглүүлэх шаардлагатай байна.

Суутган төлөх татвар болон ТӨК-ийн амлалтын талаар:

ХөОГ-ний 2.8, 2.9, НӨОДТХНГ-ний 18 дахь заалтуудад суутган татварын асуудлуудыг тодорхойлсон байдаг бөгөөд ОТ ХХК-иас 2015 оны 05 сарын 15-ны өдрийн 1186/1 тоот албан бичгээр тодруулсан Монгол Улсад байрладаггүй албан татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадна гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний төлбөрт ногдох суутган татварын талаар авч үзэхэд "...суутган татвар" гэсэн нэр томъёо татварын хууль тогтоомжид байхгүй бөгөөд харин "суутгагч" гэсэн нэр томъёог хууль тогтоомжоор зохицуулсан. Гэтэл Татварын ерөнхий газар /ТЕГ/-ын 2015 оны 05 сарын 15-ны өдрийн 1/1352 тоот албан бичигт "...Монгол Улсын нутаг дэвсгэрийн гадна гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээнд хамаарах бол ААНОАТ-ын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.2.9(г)-д заасны дагуу орлогын албан татвар суутгахгүй байж болно..." гэсэн хариуг өгчээ.

Монгол Улсын нутаг дэвсгэрт буюу Монгол Улсад байнга байрладаг аж ахуйн нэгж нь Монгол Улсад байнга байрладаггүй аж ахуйн нэгжид Менежментийн үйлчилгээний төлбөрийг шилжүүлэх тохиолдолд ХөОГ-ний 2.9-т заасны дагуу 20 хувиар татвар суутган ногдуулахаар тохиролцсон байна. Иймд Менежментийн үйлчилгээний төлбөрийг Монгол Улсын нутаг дэвсгэр дээр болон биечлэн үзүүлснээс үл хамааран суутгах татварыг ногдуулан төсөвт шилжүүлэх үүргийг ОТ ХХК хүлээнэ. Мөн менежментийн үйлчилгээний төлбөрийн асуудлыг ХөОГ-ний 2.9-т тусгайлан заасан тул ХөОГ-ний 2.8.3-т "Монгол Улсад оршин суугч бус татвар төлөгчийн Монгол Улсын нутаг дэвсгэр дээр борлуулсан бараа, гүйцэтгэсэн ажил, үзүүлсэн үйлчилгээний орлогод 20 хувиар татвар ногдуулах" гэж заасан зохицуулалтаар татварын хууль тогтоомжид заасан суутгагчийн үүргээс чөлөөлөгдөхгүй юм. Уг асуудлыг шийдвэрлэснээр:

1.Дундын суутгалын татварыг бүх эх үүсвэрээс авах, ингэснээр Монгол Улсын Татварын ерөнхий хуулийн /2008.5.20-ний өдөр/ 24.5-д заасан "Татварын хууль тогтоомжийг улсын хэмжээнд нэг мөр дагаж мөрдөх нөхцөлийг бүрдүүлэх, түүний биелэлтийг хангахтай холбогдуулан татварын албаны удирдах дээд байгууллагаас хууль тогтоомжид нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалыг хуулийн этгээд, хувь хүн дагаж мөрдөнө" гэж заасан нөхцөлийг бүрдүүлэх;

2.Зардал санаатайгаар өсөх боломж буурснаар алдагдал буурна;

3.Хуулийн зөв хэрэглээ үүснэ гэж урьдчилан дүгнээд байна.

Зардлын хэтрэлтийн талаар:

НӨОДТХНГ-ний 8.1 дэх заалтын:

(б) Үүнээс хойш Компани (эсхүл Менежментийн баг) нь Санхүүгийн жил эхлэхээс өмнө тухайн Санхүүгийн жилд хэрэгжүүлэх Компанийн үйл ажиллагааны хөтөлбөр болон төсвийн төслийг жил бүр боловсруулж ТУЗ-д батлуулахаар хүргүүлнэ.

(в) ТУЗ тухайн Санхүүгийн жил эхлэхээс доод тал нь 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө үйл ажиллагааны хөтөлбөр бүр болон төсвийг хэлэлцэн шийдвэрлэнэ. Хөтөлбөр болон төсвийг баталснаар Компани болон Менежментийн баг нь тухайн хөтөлбөр болон төсвийг хэрэгжүүлэхэд шаардлагатай бүх арга хэмжээг авч, зөвшөөрөгдсөн бүх зарлагыг гаргах эрхтэй болно.

(г) Шаардлагатай тохиолдолд Компани (эсхүл Менежментийн баг) нь шинэчлэн найруулсан, эсхүл нэмэлт оруулсан хөтөлбөр болон төсвийг боловсруулж ТУЗ-д батлуулахаар хүргүүлж болно." гэжээ.

Хөрөнгө оруулалтын гэрээнд үндэслэн хийгдсэн 2010 оны ТЭЗҮ-д ОТ төслийн хөрөнгө оруулалтын зардлыг маш тодорхой байдлаар нарийвчлан тооцсон байсан бол 2015 оны ТЭЗҮ болон ДУББСТ-өөр зардлын хэтрэлтийг хүлээн зөвшөөрч, улмаар цаашид зардал нь олон улсын хэмжээний дундаж зардлын хэтрэлтээс хэд дахин илүү байхаар байна. ТЭЗҮ 2015 нь Оюу Толгой бүлэг ордыг хамруулан боловсруулсан ба ТЭЗҮ 2010-г үгүйсгэж, төслийн үйл ажиллагааг олон үе шаттай (Оюут, Хюго 1-р давхар, цаашид Хюго 2-р давхар, Өмнөд Хюго, Херуга г.м) болгон хувааж, төслийн үе шат бүрд ТЭЗҮ боловсруулахаар болсон мөн төслийн хөрөнгө оруулалтын зардал асар их хэмжээгээр нэмэгдсэн байгаагаас харахад ТЭЗҮ-ийг хүлээн авахдаа дараах арга хэмжээг авах шаардлагатай байна. Үүнд:

1. Боловсон хүчний чадавхыг олон улсад Санхүүгийн модель боловсруулах чиглэлээр олон жил ажилласан туршлагатай байгууллагуудад бэлтгэх шаардлагатай. Нэн ялангуяа ТЭЗҮ хүлээн авагч Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлд орж буй байгууллагуудын боловсон хүчнийг бэлтгэх;

2. Манай улсын хөгжлийн түншүүд болох Азийн хөгжлийн банк, Дэлхийн банк, Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага зэрэг олон улсын байгууллагууд ч энэ чиглэлийн техник туслалцаа, тусламжийг үзүүлдэг ба энэхүү харилцааг ашиглаж, мэргэжлийн боловсон хүчнийг санхүүгийн шинжээч, техникийн экспертүүд болон модель аудиторын чиглэлээр бэлтгэх;

3. ТЭЗҮ-ийг боловсруулахад Санхүүгийн загвар маш чухал бөгөөд excel томъёотой файлаар, талуудын хүртэх үр өгөөжийн тооцоолол зэрэг зайлшгүй тооцоолсон мэдээллүүдийг агуулсан байх, аливаа түгжээгүйгээр ирүүлдэг байхаар журам боловсруулж, мөрдүүлэх;

4. Аливаа Хөрөнгө оруулалтын гэрээг байгуулахаас өмнө зайлшгүй ТЭЗҮ нь холбогдох хууль тогтоомжийн дагуу батлагдсан байх ёстой гэсэн шаардлагыг Хөрөнгө оруулалтын хууль болон холбогдох бусад хуульд нэмэлт өөрчлөлт оруулах санал боловсруулж, үр дүн биелэлтийг 2019 оны 2 дугаар улиралд багтаан УИХ-ын Эдийн

засгийн байнгын хороо (ЭЗБХ)-нд танилцуулах зэрэг асуудлуудыг шийдвэрлэх зүйтэй гэж үзсэн болно.

Дээрх асуудлыг шийдвэрлэснээр Стратегийн хөрөнгө оруулагчийг ашигтай ажиллуулахад чиглүүлэх үр дүн гарна гэж урьдчилсан байдлаар тооцоод байна.

3/ Техникийн асуудал хариуцсан ажлын дэд хэсгийн хүрээнд:

Ажлын хэсгийн төлөвлөгөөнд багтсан дараахь асуудлаар санал, дүгнэлт боловсруулахаар ажиллаж байна. Үүнд:

- Байгаль орчны нөхцөл байдлын үнэлгээг шинэчлэн хийлгэх, Усны нөхцөл байдлын үнэлгээг шинэчлэн хийлгэх талаар;
- Хөрөнгө оруулалтын гэрээний 7.3-т заасан Оюу Толгой төслийн нийт эрчим хүчний хэрэгцээг Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эх үүсвэрээс хангах үүргийг хэрэгжүүлэх арга хэмжээ авах асуудлаар Эрчим хүчний яамны Ажлын хэсэг, "Төслийн Удирдах Хороо"-ноос гаргах шийдвэртэй танилцаж, санал дүгнэлт гаргах талаар;
- Хөрөнгө оруулагч талаас нийгмийн хариуцлагын сан байгуулж, Улс орны хэмжээнд төслүүд хэрэгжүүлэх асуудлаар санал дүгнэлт гаргах талаар;
- Бүлэг ордын тусгай зөвшөөрлийг эзэмшдэг Антре гоулдын асуудлаар Монголын талаас авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээг тодорхойлж, танилцуулах талаар;
- Оюу Толгой ордын зэс, алт, мөнгө болон бусад дагалдах элементийн нөөцийн үнэлгээг Монгол Улсад мөрдөгдөж байгаа олон улсын стандартын дагуу дахин хийж эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулах талаар явцын тайлан;
- Нөөцийн үнэлгээнд үндэслэн техник, эдийн засгийн үндэслэлийг дахин боловсруулж, эрх бүхий байгууллагаар дүгнэлт гаргуулах талаар;
- Оюу Толгой төслийн Гүний уурхайн бүтээн байгуулалтын ажил чулуулгийн нөхцөл байдал, геотехникийн дүн шинжилгээнээс хамаарч зураг төсөл өөрчлөгдөж, гүний уурхайн тогтвортой үйлдвэрлэл 16-30 сар хойшилж, капитал зардлын хэмжээ 5.3 тэрбум ам.доллараос 1.2-1.9 тэрбум ам.доллараар нэмэгдэхээр байгаа асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах талаар;
- Оюу Толгой төслийн экспортын бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох үнэлгээ болон борлуулалтын орлогыг хянах зорилгоор лабораторийн хяналтыг хийх асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах талаар.

Хоёр. Тогтоолын 1.2-т: "Монгол Улсын Засгийн газар, Эрдэнэс Оюу Толгой ХХК болон Туркойс Хилл Ресурсес Лтд, Ти Эйч Ар Оюу Толгой Лтд, Оюу Толгой Нидерланд Би Ви, Рио Тинто Интернэшнл Холдингс Лтд, Оюу Толгой ХХК хооронд 2015 оны 05 дугаар сарын 18-ны өдөр байгуулсан "Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн төлөвлөгөө" болон "Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалт, санхүүжилтийн нэмэлт төлөвлөгөө"-г Монгол Улсын эрх ашиг, хууль тогтоомжид нийцүүлэн сайжруулах;" гэсний хүрээнд:

Уг заалттай холбогдуулан Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Наранцогтоос 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн Н/09 дугаартай "нууц"-ын дардастай, "Нэн яаралтай санал авах тухай" албан бичгийг ирүүлээд байна.

Уг албан бичигт Рио Тинтогийн Зэсийн группийн Бизнес хөгжил эрхэлсэн захирал Аршад Сайедийн гарын үсэгтэй, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Тэргүүн дэд дарга Б.Ганбатад хаяглагдсан Англи хэл дээрх "нууц"-ын тэмдэглэгээтэй 2021 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн албан захидал (Монгол хэл дээрх албан бус орчуулгын хамт) -ыг хавсарган ирүүлсэн бөгөөд түүнд "2021 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн уулзалтаар тавьсан саналын дагуу Рио Тинто болон Туркойз Хилл Ресурсийн хариу байр суурийн тухай" дурдагджээ.

Дээрх "нууц"-ын дардас бүхий албан бичиг, түүнд хавсаргасан албан захидлын хүрээнд санал боловсруулах, хариу өгөх ажиллагаа хийгдэж байна.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолын 1.3-т: *"Оюу Толгой төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг Хөрөнгө оруулалтын гэрээ болон 2010 оны техник, эдийн засгийн үндэслэлийн тооцоололд зааснаар нэрлэсэн үнээр 53 хувиас бууруулахгүй байх хүрээнд Монголын талын эзэмшлийн 34 хувийн хувьцаа эзэмшлийг бүтээгдэхүүн хуваах нөхцөл, эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулах хувилбаруудыг судлан шийдвэрлэх, шаардлагатай тохиолдолд холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах тухай санал боловсруулан Улсын Их Хуралд танилцуулах;"* гэжээ.

Ашигт малтмалын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2.1¹ дэх заалтад "Эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөр стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, **хэмжээг гэрээний нөгөө талд шилжүүлэхээр талууд тохиролцсон тохиолдолд төрийн эзэмшлийн хувь, хэмжээг шилжүүлэн авч байгаа тал буюу ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч нь** стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийг энэ хуулийн 47.2-т заасан журмын дагуу тооцож улсын төсөвт төлнө." мөн зүйлийн 47.2.2 дахь заалтад "Энэ хуулийн 47.2.1-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээг Засгийн газар батална." түүнчлэн 47.2.3 дахь заалтад "Энэ хуулийн 5.3-5.5-д заасан стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордын ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрийн хувь, хэмжээ нь тухайн ордын онцлогоос хамаарч 5 хувиас хэтрэхээргүй байна" гэж тусгагджээ.

¹ /Энэ зүйлийг 2015 оны 2 дугаар сарын 18-ны өдрийн хуулиар нэмсэн/

Үүнээс Төрийн эзэмшлийн хувь, хэмжээг бусдад шилжүүлэн АМНАТ-ын тусгай төлбөр ногдуулах тохиолдолд дараахь үр дагаврууд гарах урьдчилсан тооцоо байна:

-Ашигт малтмалын ордын төрийн эзэмшлийн хувь, хэмжээг гэрээний нөгөө тал сонирхсон тохиолдолд шилжүүлж болно;

-Холбогдох гэрээнүүд болон түүгээр хүлээсэн Хөрөнгө оруулагчийн үүрэг, хариуцлагууд хүчингүй болно;

-Одоогийн байдлаар ОТ төсөлтэй холбоотой холбогдох бүх гэрээ болон лиценз, хөрөнгө, данс зэрэг нь Гуравдагч этгээдээс авсан зээлийн барьцаанд байгаа.

Монголын талын эрсдэлийн хувьд:

- Тайлант хугацаанд хуримтлагдсан санхүүжилтийн өр² (үндсэн зээл, хүү) төлөх асуудал;
- Нийгмийн бүлгүүдийн дунд маргаан дагуулах/Улс төрийн эрсдэл;
- Хөрөнгө оруулалтын гэрээгээр тогтворжуулсан татварын хуулиуд хүчингүй болж одоо мөрдөгдөж буй Монгол Улсын татварын багц хуулиуд үйлчилж эхлэх эсэх нь эргэлзээтэй;
- Монгол Улсын Үндсэн хуулийн 6.2-д заасантай нийцэх эсэх;
- Төрийн эзэмшлийн хувь хэмжээний үнэлгээний асуудал тодорхойгүй байгаа;
- Ордын нөөцийг бууруулж, богино хугацаанд сорчилж олборлож дуусгах эрсдэл;
- УИХ-ын 2008 оны 40, 2009 оны 57 дугаар тогтоолуудад төрийн эзэмшлийн хувь хэмжээг 50-иас доошгүй хэмжээнд хүргэх гэсэнтэй зөрчилдөх зэрэг болно.

Үүнээс Монголын талын хувьцааны одоогийн үнэ цэнэ нь зах зээлийн үнээс бага байх тохиолдолд Монголын тал хөрөнгө оруулагч талд өртэй үлдэх төсөөлөлтэй байна. Тодруулбал,

- 2020 оны 12 дугаар сарын 31-ны байдлаар Монгол Улс АйВиЭн³-д үндсэн төлбөр \$ 1,378.4 сая, хуримтлагдсан хүү \$ 804.4 сая, нийт \$ 2,182.8 сая зээл, хүүгийн төлбөрийн үлдэгдэлтэй байна.

² НӨОДТХНГ-ний 16.6-(в)Хэрэв ТӨК 100 (нэг зуун) хувь Төрийн өмчлөлд болон түүний хяналтад байгаа больсон (тухайлбал, ТӨК-ийн хувьцааг хөрөнгийн биржээр дамжуулан арилжсаны үр дүнд) тохиолдолд Айвенхоугийн Хувь нийлүүлэгчид холбогдох шийдвэр гарган ТӨК-д бичгээр мэдэгдэл ирүүлмэгц тухайн үеийн аливаа Үлдэгдэл төлбөрийг АйВиЭн-ийн санхүүжүүлэгчид (хэрэв Айвенхоугийн Хувь нийлүүлэгчдээс чиглэл өгсөн бол АйВиЭн-ийн санхүүжүүлэгчийн нэрийн өмнөөс АйВиЭн, эсхүл ОТН-д төлнө) бүхэлд нь шууд төлөх үүрэг хүлээнэ гэж заасан байдаг.

³ ТӨК нь 34%-ийг бүрэн эзэмшиж байх тохиолдолд НӨОДТХНГ-ний 11.4(д)-д заасны дагуу ногдол ашгаар хариуцахаас бусад тохиолдолд ТӨК эсхүл Монгол Улсын Засгийн газар нь Үлдэгдэл төлбөрийн аль ч хэсгийг

Үүнтэй холбогдуулан Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2020 оны 3 дугаар сарын 12-ны өдөр "Шинжээчдийн хэсэг томилох тухай" А/40 дүгээр тушаалаар шинжээчдийг томилсон. Өнгөрсөн хугацаанд Шинжээчийн хэсэг ажиллаж тайлангийн танилцуулгатай танилцаж, 17 бүлгийн 150 гаруй асуулт, шүүмж бүхий нэгдсэн дүгнэлтийг гарган ОТ ХХК-д хүргүүлэн, шүүмжийн дагуу бүрэн хангалттай хариулт, тайлбар авахаар ажилласан.

Энэхүү нөөцийн тодотгол тайлангаар өмнө нь 2014 онд Улсын нэгдсэн бүртгэлд бүртгэгдсэн Оюу Толгойн зэс-алтны бүлэг ордын ашигт малтмалын нөөцийг тооцоолсон ил уурхайн захын агуулга 0.22 байснаас 0.24 хувь, далд уурхайн захын агуулга 0.37 байснаас 0.41 хувь болж өссөний улмаас 2014 оны бүртгэгдсэн нөөцөөс хүдэр 523.8 сая.тн, зэс 1.39 сая.тн, алт 56 тн, мөнгө 423 тн, молибден 19 мян.тн-оор тус тус буурах нөхцөл байдал үүсэхээр байна.

ОТ ХХК-иас захын агуулга өсөх болсон гол шалтгааны 66 орчим хувийг цахилгаан эрчим хүчний урт хугацааны үнийн өсөлт буюу "Таван Толгой нүүрсний цахилгаан станцын суурилсан эрчим хүчний гуравдагч талын үйл ажиллагааны нийлүүлэлтийн загвараас үүдэлтэй зардлын нэмэгдэл" гэж тайлбарласан.

Мөн Монгол Улсын Засгийн газар шинэчлэн байгуулагдсантай холбоотойгоор Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Үндэсний Геологийн албаны бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулсантай холбогдуулан тус яамны дэргэдэх ЭБМЗ-ийн дүрэм болон бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах зайлшгүй шаардлага үүссэн, мөн дэлхий даяар Ковид-19 цар тахлын улмаас үүсээд байгаа нөхцөл байдал буюу давтагдашгүй хүчин зүйл зэрэг асуудлуудаас үүдэн хайгуулын ажлын тодотгол тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар хэлэлцүүлж, ордын нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлэхэд тодорхой хэмжээний цаг хугацааны хүчин зүйл нөлөөлөөд байна. Ковид-19 цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалан хайгуулын ажлын тодотгол тайланг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн хуралдаанаар ойрын үед хэлэлцэхээр ажиллаж байна.

Түүнчлэн, Рио Тинто компаниас 2019 оны 7 дугаар сарын 16-ны өдөр ОТ ХХК-ийн Гүний уурхайн төслийн өөрчлөлт, үнэлгээнүүдийн үр дүнгээс шалтгаалаад гүний уурхайн тогтвортой үйлдвэрлэл 2016 оны ТЭЗҮ-д заасан хугацаанаас 16-30 сараар хойшлох, төслийн бүтээн байгуулалтын капитал зардал 5.37 тэрбум ам.доллаароос 1.2-1.9 тэрбум ам.доллаароор нэмэгдэхээр байгаа талаар мэдээлж байсан.

"Оюутолгой" ХХК-иас 2019 онд хүдрийн биетэд хийсэн геотехникийн болон тогтцын судалгаагаар Хойд Хюго ордын ашиглалтын 1-р давхар Гүний уурхайн төслийн "0" Панелийн зураг төслийг хэрэгжүүлэхэд томоохон эрсдэл байгааг тогтоож, Геотехникийн эрсдэлээс сэргийлэх үүднээс уурхайн зураг төсөлд оруулах өөрчлөлт буюу "0" Панелийн урьдчилсан судалгааны дүн шинжилгээгээр ОТ ТЭЗҮ 15-д заасан тогтвортой үйлдвэрлэл эхлэх хугацаа 21-29 сараар хойшилж, одоогийн төсөв болох 5.37 тэрбум ам.доллар нь 1.2-1.8 тэрбум ам.доллаароор нэмэгдэх асуудлыг багтаасан ОТ ТЭЗҮ 2020-ыг ЭБМЗ-д 2020 оны 7 дугаар сарын 1-ний өдөр хүргүүлсэн.

Харин УУХҮЯ-аас нөөцийн тодотгол тайланг ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэж, нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэсний дараа "Техник-эдийн засгийн үндэслэл"-ийг хүлээн авч, шинжээчийг томилон

ажиллуулан, ЭБМЗ-ийн хуралдаанаар хэлэлцэх боломжтой талаар хариуг хүргүүлээд байна.

Үүний дараагаар ОТ ХХК-иас 2020 оны 12 дугаар сард болсон ТУЗ-ийн ээлжит бус хурлаар тухайн ТЭЗҮ-д туссан асуудлуудыг дахин шинэчлэн, мөн Ковид-19 цар тахлын мэдэгдэж буй нөлөөллүүдийг төслийн өртөг, хуваарьт засварлан тусгаж, шинэчилсэн тооцооллыг батлуулахаар танилцуулсан.

Тооцоололд тогтвортой үйлдвэрлэлийг 2022 оны 10 дугаар сар буюу 2015 оны ТЭЗҮ-д заасан хуваариас 21 сарын дараа эхлүүлэх, бүтээн байгуулалтын капитал зардлын дүн 6.8 тэрбум ам.доллар байгаа нь ТЭЗҮ 2015-д туссан 5.3 тэрбум ам.доллараас 1.5 тэрбум (26%)-аар өссөн асуудлыг тусгасан. Мөн цаашид геотехникийн нэмэлт судалгааг Хойд Хюгогийн 1 болон 2 дугаар панельд хийж байгаатай холбоотой зураг төсөл дахин өөрчлөгдөж, зардлын өөрчлөлт гарах нөхцөл байдал үүсэхээр байна.

Үүнтэй холбогдуулан Монголын талаас Тусгай хороо байгуулах асуудлыг санаачлан тавьсан ба Тусгай хороог далд уурхайн бүтээн байгуулалтын хугацаа хойшилж, зардал нэмэгдсэн асуудлын шалтгааны талаар хөндлөнгийн дүгнэлт гаргуулах, энэ зорилгоор төсөл хэрэгжүүлэх, уурхайн төлөвлөлт, зардлын менежмент болон/эсхүл бусад холбогдох салбарын мэргэшсэн шинжээчдийн нэр хүндтэй, хөндлөнгийн зөвлөх компани (цаашид "Шинжээч" гэх)-ийг сонгон ажиллуулж, Шинжээчийн дүгнэлтийг аль болох хурдан хугацаанд буюу 6 сараас хэтрэхгүй хугацаанд хүлээн авч, ТУЗ-д танилцуулах чиг үүрэг бүхий, 4 хүний бүрэлдэхүүнтэй байгуулах шийдвэрийг "дийлэнх олонхын дэмжсэн санал"-аар баталсан(Туркойз Хилл Ресурс болон Монголын талыг төлөөлсөн зургаан гишүүдийн дэмжсэн санал). Тус хороо нь ТУЗ-ийн ЭОТ ХХК-иас нэр дэвшүүлсэн хоёр гишүүн, Туркойз Хилл Ресурс компаниас нэр дэвшүүлсэн хоёр гишүүнтэйгээр ажиллаж байгаа бөгөөд Шинжээч сонгон ажиллуулах Ажлын цар хүрээг боловсруулан, сонгон шалгаруулалтыг хийхээр ажиллаж байна.

Хүснэгт.Зардлын өөрчлөлт болон хугацаа хойшлолт

Ангилал	Нэр төрөл		сая ам.доллар, нэрлэсэн утгаар		
			ОТТЭЗҮ 2015	2020 оны Тооцоолол	Зөрүү
Босоо	1100	Босоо ам 2	439	630	191
	1200	Босоо ам 1	14	16	1
	1300	Босоо ам 3	358	308	(50)
	1400	Босоо ам 4	390	326	(63)
	1500	Дундын байгууламжууд (Босоо ам 2)	108	86	(22)
Нийт босоо ам			1,310	1,366	57

Гадарг -ын байгуу -ламж	1500	Дундын байгууламжууд (уурхайн ажилчдын хувцас хатаах байр, агуулах, гадаргын байгууламжууд)	114	184	69
	2000	Төслийн талбайн бэлтгэл ажил, ус шавхах, засал, голын голдирул өөрчлөх, уурхайн цогцолборын ахуйн зардал	24	92	68
	3000	Баяжуулах үйлдвэрийн шинэчлэл	295	346	51
	5200- 5600	Эрчим хүч, ус / бохир ус цэвэршүүлэх, мэдээллийн систем, технологи	77	77	0
	5700	Туслах байгууламжууд (үйл ажиллагааны агуулах, төвлөрсөн дулааны станц, дулаан түгээх систем, химийн бодис хадгалах байгууламж)	109	265	156
	6000	Нэвтрэх зам, үйл ажиллагааны кемп (ОТ- Гашуунсухайтын зам, Оюут кемп II, үйл ажиллагааны кемп)	356	253	(103)
Гадаргын байгууламжууд ын нийт			975	1,218	242
Гүний уурхай	1500	Дундын байгууламжууд (налуу	62	111	48
	1600	Гүний уурхайн бүтээн	1,007	1,390	383
	8400	Гүний уурхайн олборлолтын	767	895	128
	1800	Гүний уурхайн дэд бүтэц ба	1,218	1,765	547
Гүний уурхайн нийт			3,055	4,161	1,106
Бүтээн байгуулалтын капитал зардлын нийт			5,340	6,745	1,405

	ТЭЗҮ 2015 Ажил эхлүүлэх мэдэгдэл	Панель '0'-ийнТЭЗҮ-д заасан тооцоолол (Ковид- 19-ийн нөлөөлөл орсон)
Босоо ам №1 болон хацарт бутлуур	2017/III сар	2017/X сар
Босоо ам №5	2017/X сар	2018/V сар
Орон байр, кемп	2020/IX сар	2018/X сар
Босоо ам №2-ын үйлчилгээний ба	2018/VII сар	2019/X сар
Уурхайн хатаалгын байгууламж	2018/V сар	2019/IX сар
Панель 0-ийн огтлох малталтыг эхлүүлэх	2019/IX сар	2021/VI сар (+21)

Анхдагч бутлуур №1 (Материал зөөвөрлөх)	2019/XII сар*	2022/I сар
Панель '0'-ийн эхний хүдэр буулгуур	2020/IV сар	2022/II сар (+22 сар)
Панель '0'-ийн тогтвортой үйлдвэрлэл	2021/I сар	2022/X сар (+21)
Бүтээн байгуулалтын төсөл дуусах	2022/IX сар	2025/V сар

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолын 1.5-д: *"Байгаль орчны болон усны нөхцөл байдлын үнэлгээг шинэчлэн хийлгэж, Монгол Улсын Засгийн газрын 2011 оны 06 дугаар сарын 08-ны өдрийн 175 тоот "Газрыг улсын хэрэгцээнд авах тухай" тогтоолыг өөрчилж, говийн бүсийн гүний ус ашиглах нөхцөлийг харгалзан тогтоох,"* гэжээ.

Тус заалтыг хэрэгжүүлэх талаар Техникийн хамтарсан хэсгийн төлөвлөгөөнд туссан ба урьдчилсан байдлаар доорх саналыг ирүүлсэн байна.

- **Хууль тогтоомжийн талаар:**

Монгол Улсын Үндсэн хуулийн зургаадугаар зүйлийн 6.1-д "...Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна..." гэж, 6.2-д "...Монгол Улсын иргэдэд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн..." гэж *Монгол Улсын Үндсэн хуульд заасан. Гэтэл Оюу толгойн Хөрөнгө оруулалтын гэрээг 2009 онд байгуулах үед Усны тухай хуулийн холбогдох заалтуудыг өөрчилж нэмэлт оруулсан нь ус ашиглагчид давуу эрх олгосон байна. Иймээс уг гэрээний 6.13, 6.13.1, 6.13.2, 6.17, 6.18 зүйл заалтуудыг Үндсэн хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцүүлэн өөрчлөлт оруулах шаардлагатай байна.*

- **Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний талаар:**

2009 онд Монгол Улсын Засгийн газар, Айвенхоу майнз Монголия ХХК-ний хооронд "Оюу толгой" төслийн хөрөнгө оруулалтын гэрээ байгуулснаас хойш уг ордыг ашиглах чиглэлээр үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой 37 төсөлд байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээний тайлан боловсруулж Байгаль орчин, аялал жуулчлалын яамны Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний мэргэжлийн зөвлөлөөр хэлэлцүүлэн батлуулсан байна.

Оюу толгой төслийн хөрөнгө оруулалтын гэрээний 6.4 дэх хэсэгт байгаль хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн хараат бус, мэргэшсэн, эрх бүхий шинжээчийн тайланг 3 жил тутам яаманд ирүүлж байхаар заасан боловч төсөл хэрэгжүүлэгч өнөөг хүртэл уг заалтыг хэрэгжүүлээгүй үүнтэй холбогдуулан уг гэрээний 6.5 дэх хэсэгт энэ тайлан олон нийтэд нээлттэй байхаар заасан нөхцөл хангагдахгүй байна.

Оюу толгой төслийн үндсэн болон туслах үйл ажиллагааны улмаас төсөл хэрэгжиж эхэлсэн цагаас байгаль орчин хүний эрүүл мэндэд үзүүлсэн сөрөг нөлөөллийг судлан тогтоох шаардлагатай талаар иргэний нийгмийн байгууллага, орон нутгийн иргэд санал хүсэлт тус яаманд удаа дараа ирүүлж байгаа тул Байгаль

орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 6.3 дэх хэсэгт заасны дагуу хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ хийх шаардлагатай гэж үзэж байна.

- **Усны нөөцийг шинэчлэн тогтоох талаар:**

Оюу толгой төслийн ус хангамжийн зориулалтаар нээж илрүүлсэн Гүний хоолойн газрын доорх усны ордын хайгуулын ажлыг 2003-2007, 2015 онуудад явуулж усны нөөцийг үйлдвэрлэлийн зэргээр 918 л/с-ээр ашиглахаар батлуулж, ус ашиглах гэрээг 25 жилийн хугацаатай (2016.06.07-2040.06.07) байгуулсан байна.

Оюу толгой төслийн Хөрөнгө оруулалтын гэрээг 2009 онд байгуулахдаа хөрөнгө оруулагч талын шахалтаар Усны тухай хуульд 4 зүйлийн нэмэлт өөрчлөлт оруулсан нь **Монгол Улсын Үндсэн хуулийн 6.1, 6.2 дахь заалтуудтай зөрчилдөж байгаа тул уг гэрээний (6.13, 6.13.1, 6.13.2, 6.14, 6.17, 6.18, 6.19.1) холбогдох заалтуудыг хуульд нийцүүлэн өөрчлөн найруулах шаардлагатай байна.**

- **Говийн бүсийн газрын доорх ус ашиглах нөхцөлийн талаар:**

Өнөөдрийн байдлаар "Оюутолгой" ХХК нь батлагдсан усны нөөцийн 57-80 хүртэл хувийг ашиглаж байгаа бөгөөд үйлдвэрийн хүчин чадал нэмэгдэж усны нөөцийг 100%-д хүргэн ашиглах тохиолдолд газрын доорх усны ордод сөрөг нөлөөлөл үзүүлэх эрсдэлтэй. Учир нь Говийн бүсийн газрын доорх усны нөөцийн нөхөн сэлбэгдэх хугацаа удаан байдаг тул усны нөөцийг хомсдуулахаас урьдчилан сэргийлж гадаргын усыг хуримтлуулж хосолмол байдлаар ашиглах төсөл хэрэгжүүлэх шаардлагатай байна. Газрын доорхи усны ашиглалт хэрэглээ нэмэгдэж байгаатай холбогдуулан Гүний хоолойн газрын доорх усны орд, олборлолтод өртөж байгаа талбай, ил уурхай, хаягдлын сан, Ундайн голын сайр дагуу 271 цооногт, 69 ардын гар худагт мөн 11 булгийн усны нөөц горимын ажиглалтыг бүрэн болон хагас автомат төхөөрөмжөөр нийт 351 цэгт хэмжилтүүдийг хийж байна. Өнөөдрийн байдлаар цооногуудын усны түвшин, бууралтын зөвшөөрөгдөх доод хязгаараас доошилсон тохиолдол илрээгүй байна. ОТ ХХК нь усны нөөц ашигласны төлбөрийг Ус ашиглах дүгнэлт, гэрээ болон холбогдох хууль, журмын дагуу Өмнөговь аймгийн төсөвт жил бүр төлж байна. 2011-2019 оны хооронд 104.3 сая /м3 ус ашиглаж, ус ашигласны төлбөрт 100 тэрбум төгрөг төлсөн байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн дагуу 2020 онд Гүний хоолойн газрын доорх усны ордыг ашиглах төслийн үнэлгээний тайланд тодотгол хийнэ." гэсэн байна.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолын 1.6-д: *"Монгол Улсын Их Хурлын даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн 57 дугаар захирамжаар байгуулагдсан Оюу Толгой ордыг ашиглах хөрөнгө оруулалтын гэрээний хэрэгжилтийг шалгах үүрэг бүхий Ажлын хэсгийн санал, дүгнэлтийг хэрэгжүүлэхэд чиглэсэн цогц арга хэмжээ авах,"* гэжээ.

Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 02 дугаар сарын 09-ний өдрийн 45 дугаар захирамжаар "Оюу Толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" Улсын Их Хурлын 2019 оны 92 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах, Оюу Толгой төслийн гадны хөрөнгө оруулагч талтай

хэлэлцээ хийх, төслийг тохирох, эцэслэсэн хувилбарыг Засгийн газрын хуралдаанд танилцуулах үүрэг бүхий Ажлын хэсгийг шинэчлэн байгуулж, Ажлын хэсгийн даргаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, гишүүнээр Улсын Их Хурлын гишүүд болон Гадаад харилцааны сайд, Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, Эрчим хүчний сайд, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга, ЭОТ ХХК-ийн Гүйцэтгэх захирал нар, нарийн бичгийн даргаар Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ажиллаж байна.

Монгол Улсын Их Хурлын 2019 оны 11 дүгээр сарын 21-ний өдрийн "Оюу толгой ордын ашиглалтад Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай" 92 дугаар тогтоолын 1.7-д *"Оюу Толгой төслийн Монголын талын төлөөллийг хэрэгжүүлэгч байгууллагын санхүүгийн болон хүний нөөцийн чадавхыг олон улсын түвшинд хүргэж, бэхжүүлэх."* гэжээ.

Уг заалтын хэрэгжилтийг хангуулахтай холбогдуулан "Эрдэнэс оюутолгой" ХХК-ийн үйл ажиллагааны үндсэн чиг үүрэг, хүний нөөцийн одоогийн байдал, цаашдын хэрэгцээнд тулгуурлан зохих судалгаа хийгдсэн юм. Тухайлбал,

"Эрдэнэс оюутолгой" ХХК-ийн дүрмийн 3.3 дахь заалтад тус компани нь:

- "Оюу Толгой" ХХК-ийн төрийн эзэмшлийн хувьцааг эзэмших эрхийг хэрэгжүүлэх;

- Хувьцаа эзэмшигчийн хувьд ОТ ХХК-ийн үйл ажиллагаанд оролцох;

- Оюу Толгойн ашигт малтмалын ордыг ашиглах үеийн төрийн оролцоог хэрэгжүүлэх;

- Төрд ногдох ашгийг төвлөрүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлтэй бөгөөд Улсын Их Хурал дээр дурдсан тогтоолын хэрэгжилтийг хангуулахад хүний нөөцийн хувьд дараах хэрэгцээ тодорхойлогдсон. Үүнд:

Санхүүгийн шинжилгээ хийх ажлын чиглэлээр:

- Оюу Толгойн санхүүгийн байдал, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд санхүүгийн нягтлан шалгах ажиллагааг гүйцэтгэж, Монголын талын хүртэх ногдол ашгийг хойшлуулж буй үндэслэл, ил уурхай болон далд уурхайн бүтээн байгуулалтын хөрөнгө оруулалтын зардлын хэтрэлт, үйл ажиллагааны зардлын үр ашгийг нягтлах;
- Оюу Толгой төслийн хүрээнд хөрөнгө оруулагчдын гаргасан барьцаа хөрөнгө, баталгаа, амлалт, татан төвлөрүүлсэн хөрөнгийн хүүгийн түвшин, даатгалын нөхцөлүүдийг нягтлан хянаж, тэдгээрийн өртөг нөлөөлөх нөлөөллийг тодруулах, барьцааны хураамжийг дахин нягтлах, тэдгээр төлбөрийг бууруулах чиглэлээр зөвлөмж өгөх;
- 2010, 2015 болон 2020 онд шинэчилсэн ТЭЗҮ-ийн санхүүгийн загварчлалыг нягталж, санал, дүгнэлт боловсруулах;

- Оюу Толгой төсөлтэй холбогдох бүх гэрээг хянаж, УИХ-ын 92-р тогтоолын хэрэгжилтийн хүрээнд Монголын талын хүртэх үр өгөөжийг 53 хувиас доошгүй байлгах үүднээс эдгээр гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах бүх боломж (бүтээгдэхүүн хуваах, бүрэн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хувьцаа ба нөөц ашигласны төлбөрийн хосолмол болон бусад боломжит хувилбарууд)-ын талаар санал, дүгнэлт гаргах.

Геологи, уул уурхайн шинжилгээ хийх ажлын чиглэлээр:

- Оюу Толгойн бүлэг ордын нөөц нь 2020 оны геологийн ажлын тайлангаар зардал өсөж байгаатай холбоотой буурахаар тооцооллыг ирүүлээд байна. Иймд геологи болон геотехникийн ажлын өгөгдлийг судлан, нөөцийн үнэлгээ, тайлангийн асуудлаар Монгол Улсад болон олон улсад дагаж мөрддөг стандартын хүрээнд санал дүгнэлт гаргах, блок болон панелиар олборлох технологитой холбоотой геотехник, чулуулгийн физик механикийн шинж чанарын талаар санал, дүгнэлт гаргах;
- ОТ төслийн Оюут ордыг ил аргаар бусад ордуудыг далд уурхайгаар буюу блок, панелин технологийн аргаар агуйлан нураахаар төлөвлөж байгаатай холбоотой Хойд Хюгогийн 1 дүгээр давхрын зураг төсөл нь чулуулгийн нөхцөл байдал, геотехникийн дүн шинжилгээнээс хамаарч өөрчлөгдөж байгаатай холбогдуулан геотехникийн дата мэдээлэл, зураг төслийн өөрчлөлтийн талаар санал дүгнэлт боловсруулан ажиллах мэргэжилтнийг бэлдэх шаардлага ойрын хугацаанд үүсэж байна. Цаашдаа төслийн ил болон далд уурхайн ТЭЗҮ, уулын ажлын тайлан, төлөвлөгөөний гүйцэтгэлийг хянаж харьцуулах, уул уурхайн блок болон панелиар олборлох технологийн талаар холбогдох саналыг боловсруулах, үнэлэлт дүгнэлт гаргах; *(Өнөөдрийн байдлаар Монгол Улсад анх удаа Оюу Толгой төсөлд хэрэгжүүлэх блокчлон олборлох технологи, геотехникийн загварчлал, инженерчлэл асуудлаар дотоодын мэргэжилтэн бэлтгэгдээгүй, хяналтыг хэрэгжүүлэх боловсон хүчин байхгүй байна)*
- ОТ төслийн экспортын бүтээгдэхүүнд ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр тооцох үнэлгээ болон борлуулалтын орлогыг хянах зорилгоор лабораторийн хяналтыг хийх асуудал Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын тушаалаар байгуулагдсан Ажлын хэсэг дээр хэлэлцэгдсэнтэй холбоотой уг асуудлыг судалж, санал дүгнэлт гаргах шаардлага үүссэн;
- ХөОГ-ний 7.3-т заасан Оюу Толгой төслийн нийт эрчим хүчний хэрэгцээг Монгол Улсын нутаг дэвсгэр дэх эх үүсвэрээс хангах үүргийг хэрэгжүүлэх, Өмнийн говийн бүсийн хөгжил болон Ханбогд сумын ерөнхий төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран шинэчлэх, хөгжүүлэх.

Хууль, гэрээний эрх зүй, олон улсын хувийн эрх зүйн хүрээнд шинжилгээ хийх ажлын чиглэлээр:

- Оюу Толгойн гэрээнүүдэд нэмэлт, өөрчлөлт оруулах зорилгоор УИХ-ын 92-р тогтоолыг хэрэгжүүлэхэд шаардлагатай яриа хэлэлцээрт дэмжлэг үзүүлэх чадавхыг сайжруулах;
- Оюу Толгой төслийн гэрээнүүд, холбогдох баримт бичгүүд, хууль эрх зүйн орчинд дүн шинжилгээ хийж, санал дүгнэлт гаргах;
- Оюу Толгойн далд уурхайн бүтээн байгуулалтыг санхүүжүүлэх зорилгоор байгуулсан төслийн санхүүжилтийн гэрээ болон барьцааны гэрээнүүдийг хянаж, санал дүгнэлт гаргах;
- Оюу Толгой төслөөс хүртэх Монголын талын үр өгөөжийг нэрлэсэн үнээр 53%-иас бууруулахгүй байх шаардлагыг хангаж, 34%-ийн хувьцаа эзэмшлийг бүтээгдэхүүн хуваах нөхцөл, эсвэл ашигт малтмалын нөөц ашигласны тусгай төлбөрөөр орлуулахтай холбогдуулан санал дүгнэлт гаргах зэрэг хүний нөөцийг бэхжүүлэх, өргөжүүлэх, тэдгээрийн мэдлэг, ур чадвар, туршлагыг тасралтгүй хөгжүүлэх шаардлагууд тодорхойлогдсон билээ.

Уг судалгаа, хэрэгцээ, шаардлагад тулгуурлан ЭОТ ХХК-ийн зохион байгуулалтын бүтэц, ажлын байрны тодорхойлолт, чиг үүргийн хуваарилалт, холбогдох дүрэм, журмыг шинэчлэн боловсруулж, тус компанийн Хувьцаа эзэмшигчийн хуралд хүргүүлж, танилцуулснаар тус хурлын 2020 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 02 дугаар тогтоолоор уг асуудлуудыг хэлэлцэн шийдвэрлэж, зохион байгуулалтын бүтцийн нэгжийг 3 байсныг 4 нэгж болгож, батлагдсан орон тоо 31-ийг хэвээр хадгалж, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлт хийлээ. Энэхүү өөрчлөлтийн дагуу компанийн шаардлагатай санхүүжилтийг толгой компаниас шийдвэрлэж, компанийн ажиллаж буй бүрэлдэхүүн 16 байсныг батлагдсан орон тооны дагуу ажиллуулахаар 31 болгон тус тус нэмэгдүүлээд байна.

"Эрдэнэс оюутолгой" ХХК-иас цаашид шинэчлэгдсэн зохион байгуулалтын бүтцэд нийцүүлэн компанийн болон хүний нөөцийн өмнө нь тодорхойлогдсон эрэлт, хэрэгцээг хангуулах, түүний үр дүнг бодит ажил хэрэг болгох, ижил төрлийн болон олон улсын адил үйл ажиллагаа явуулдаг бусад хуулийн этгээдтэй өрсөлдөхүйц дунд, урт хугацааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаж байна.

Асуулга 2. Айвенхоу майнз Монголиа Инк ХХК, Айвенхоу майнз Лтд, РиоТинто, Интернэшнл Холдингс Лтд компани нь Монгол Улсын Засгийн газрын эсрэг Их Британи Умард Ирландын Нэгдсэн Вант Улсын Лондон хотын Арбитрын шүүхэд хандан нэхэмжлэл гаргасан бөгөөд нэхэмжлэлийн талаар хариу тайлбар хүргүүлэх, сөрөг нэхэмжлэл гаргах хугацаа нь энэ оны 2 дугаар сарын 21-ний өдрөөр дуусгавар болох гэж байгаа тухай албан бус мэдээлэл байгаа тул хэрэв уг мэдээлэл үнэн бол хариу тайлбар, сөрөг нэхэмжлэлийг яаралтай гаргах, энэ талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай

Уг асуулгад холбогдуулан дараахь мэдээллийг хүргүүлж байна. Үүнд:

1. Татварын улсын байцаагч нар ОТ ХХК-ийн 2013-2015 оны татварын жилд хамаарах зохих тайлан, санхүүгийн баримтад хяналт, шалгалтыг хийж, хуульд заасны дагуу татварын ногдуулалт, төлөлтийн байдалд хяналт шалгалт хийж 2018 оны 1 дүгээр сарын 10-ны өдрийн №367201801 дугаартай

“Шийтгэлийн хуудас”-аар 377,1 тэрбум төгрөгийн татвар, торгууль болон алданги ногдуулжээ.

2. ОТ ХХК нь шийтгэлийн хуудсаар тогтоосон 17.4 тэрбум төгрөгийн зөрчлөө хүлээн зөвшөөрч, уг зөрчилд ногдох 5.8 тэрбум төгрөгийн торгууль, алданги, хүүг Анхны ардчилсан сонгууль болж байнгын ажиллагаатай парламент байгуулагдсаны 25 жилийн ойг тохиолдуулан өршөөл үзүүлэх тухай хуулийн үйлчлэлд ОТ ХХК нь шийтгэлийн хуудсаар тогтоосон 17.4 тэрбум төгрөгийн зөрчлөө хүлээн зөвшөөрч, уг зөрчилд ногдох 5.8 тэрбум төгрөгийн торгууль барагдуулсан байна.
3. Татварын улсын байцаагч нарын 2018 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн №367201801 дугаартай “Шийтгэлийн хуудас”-тай холбогдуулан ОТ ХХК-иас 2018 оны 01 дүгээр сарын 25-ны өдөр ТЕГ-ын Маргаан таслах зөвлөлд хандаж гомдол, 2018 оны 02 дугаар сарын 26-ны өдөр Нийслэлийн Захиргааны хэргийн анхан шатны шүүхэд нэхэмжлэл гаргажээ.
4. ОТ ХХК-ийн Захиргааны хэргийн шүүхэд гаргасан нэхэмжлэл, шүүхийн ажиллагаа дараах явцтай байна. Тухайлбал,
 - ОТ ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Амарбаясгалан ЗХШХШТ-ийн нэмэлт өөрчлөлт нь Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх маргаан Үндсэн хуулийн цэцэд хянагдаж байна. Энэхүү маргаан нь энэ хэргийг хянан шийдвэрлэхэд ач холбогдолтой байх тул эцсийн шийдвэр гартал хэргийг түдгэлзүүлэх хүсэлт гаргасныг шүүх хангаж 2018.05.17-ны өдрийн 128/Ш32018/3139 дугаар шүүгчийн захирамжаар ЗХШХШТХ-ийн 65.1.6-д заасан үндэслэлээр хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг түдгэлзүүлсэн;
 - 2019.07.10-ны өдөр 128/Ш32019/4742 дугаар шүүгчийн захирамжаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээсэн;
 - ОТ ХХК-ийн итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Амарбаясгалан 2019.10.08-ны өдөр нотлох баримт гаргуулах хүсэлт гаргасан. Шүүх 128/Ш32019/7308 захирамжаар хүсэлтийн зарим хэсгийг хангаж үлдэх хэсгийг хангахаас татгалзсан;
 - Дээрх шүүгчийн 128/Ш32019/7308 захирамжид ОТ давж заалдах журмаар гомдол гаргасан бөгөөд ЗХДЗШШ-ийн 2019.11.14 №1655 тоот захирамжаар гомдлыг хүлээн авахаас татгалзаж буцаасан;
 - 2020.01.02-ны өдөр итгэмжлэгдсэн төлөөлөгч Жанчивдорж нэхэмжлэлийн шаардлага нэмэгдүүлэх тухай хүсэлт гаргаж хуралдааныг хойшлуулсан;
 - 2020.01.09-ний өдөр ОТ ХХК шүүх хуралдаан дээр гомдлоо нэмэгдүүлсэн шаардлагыг шүүхэд гаргасныг шүүгч хүлээн авахаас татгалзаж 2020.01.09-ны өдөр 377 тоот захирамж гаргасан. ОТ ХХК эс зөвшөөрч давж заалдах журмаар гомдол гаргасан;
 - ЗХДЗШШ-ийн 2020.02.13-ны өдрийн хуралдаанаар хүсэлтийг авч хэлэлцээд 129 тоот магадлалаар анхан шатны шүүгчийн захирамжийг хэвээр үлдээж гомдлыг хангахаас татгалзсан;
 - ОТ ХХК 2020.04.22-ны өдөр Арбитрын шүүхэд гаргасан маргаан Захиргааны хэргийн шүүхэд гаргасан гомдолтой адил байгаагийн зэрэгцээ эдгээр шүүхийн шийдвэр хоорондоо харилцан хамааралтай

8. ОТ ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн ээлжит хурал дээр Аудит, санхүүгийн хорооны хурлын тайлангийн танилцуулгаар арбитрын шүүхэд хандах асуудлаар хуулийн хэлтэс арбитрт хандах шаардагдах бичиг баримтыг бэлдчихсэн байгаа талаар танилцуулжээ.
9. ОТ ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурал дээр Хуулийн хэлтсээс арбитрт хандахаар бэлтгэж байгаа ба Санхүүгийн хэлтсээс арбитрын зардалд 10.8 сая ам.доллар төсөвт тусгаад, залруулж, 6 сая ам.доллар болгосон. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд дотоодын шүүхээс шийдвэр гаргахаас өмнө арбитрт хандах талаар танилцуулжээ.
10. ОТ ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурал дээр ЭОТ ХХК-ийн зүгээс буюу Монголын талыг төлөөлсөн ТУЗ-ийн гишүүд: *"ОТ ХХК-ийн 2020 оны төсвийг хэлэлцэхдээ арбитрт хандах асуудлаар буюу татварын маргааныг шийдвэрлэх зорилгоор төсөвлөсөн арбитрын үйл ажиллагааны зөвлөх үйлчилгээний зардал 10.8 сая ам.долларыг батлахгүй байх"* "Удирдамж" чиглэлтэй оролцсон. Тухайн асуудлыг хэлэлцэхэд Монголын талын ТУЗ-ийн гишүүд эсэргүүцсэн байр суурийг илэрхийлж, батлах санал хураалтад татгалзсан бөгөөд бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн дэмжсэнээр дийлэнх олонхын саналаар баталж байв. Үүнд:
 - 2020 оны ажлын даалгаврууд буюу хамааралтай этгээдээс авах ажил үйлчилгээ, мөн татварын маргааныг шийдвэрлүүлэх арбитрын үйл ажиллагааны зардал дээр талууд санал нийлээгүй;
 - 2020 онд хамааралтай этгээдээс авах ажил үйлчилгээ, мөн татварын маргааныг шийдвэрлүүлэх арбитрын зардлыг батлахыг зөвшөөрөөгүй;
 - Хамааралтай талаас авах ажил үйлчилгээ болон арбитрын зардлын талаарх тогтоолтой холбогдуулж, Монголын талын төлөөлөл дэмжээгүй гэдгийг онцлон тэмдэглүүлж;
 - 2020 оны ажлын даалгаврууд (SOW) буюу хамааралтай талаас авах ажил үйлчилгээний болон арбитрын үйл ажиллагааны төсвийг батлах тухай тогтоолыг Монголын талын гишүүд татгалзаж, бусад бусад гишүүд дэмжсэнээр дийлэнх олонхын саналаар батлагдсан байдаг.
11. 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр ОТ ХХК-ийн Гүйцэтгэх захирлаас 505/1 тоот албан бичгээр ОТ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдэд "ТЕГ-ын Шийтгэлийн хуудас болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газар(МХЕГ)-ын албан шаардлагатай холбоотой Маргааныг Лондонгийн Олон Улсын арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх тухай мэдэгдэл"-ийг ирүүлсэн. Тус "Мэдэгдэл"-д ОТ ХХК нь ХөОГ-ний маргаан шийдвэрлэх зохицуулалтын дагуу "Шийтгэлийн хуудас болон холбогдох асуудалтай холбоотой Маргаан үүссэн тухай мэдэгдэл – Хэлэлцээ хийх хүсэлт хүргүүлэх тухай мэдэгдэл"-ийг 2018 оны 03 дугаар сард Монгол Улсын Засгийн газар (Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, БОАЖ-ын сайд)-т хүргүүлж, маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх хугацаа 2018 оны 06 дугаар сард дууссан талаар тус "Мэдэгдэл"-д дурдаж, ХөОГ-ний дагуу Лондонгийн Олон Улсын арбитрын шүүхэд хандах тухай мэдэгдсэн.
12. Лондонгийн Арбитрын шүүхээс 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн "Арбитрын мэдэгдэл", 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн "Нэхэмжлэлийн мэдүүлэг"-ийг тус тус хүлээн авч тэдгээрт хариу тайлбар өгөх асуудлаар дараах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Үүнд, Монгол Улсын Ерөнхий сайд 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 32 дугаар захирамжаар

8. ОТ ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн ээлжит хурал дээр Аудит, санхүүгийн хорооны хурлын тайлангийн танилцуулгаар арбитрын шүүхэд хандах асуудлаар хуулийн хэлтэс арбитрт хандах шаардагдах бичиг баримтыг бэлдчихсэн байгаа талаар танилцуулжээ.
9. ОТ ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурал дээр Хуулийн хэлтсээс арбитрт хандахаар бэлтгэж байгаа ба Санхүүгийн хэлтсээс арбитрын зардалд 10.8 сая ам.доллар төсөвт тусгаад, залруулж, 6 сая ам.доллар болгосон. Компани болон хувьцаа эзэмшигчдийн ашиг сонирхлыг хамгаалахын тулд дотоодын шүүхээс шийдвэр гаргахаас өмнө арбитрт хандах талаар танилцуулжээ.
10. ОТ ХХК-ийн ТУЗ-ийн 2019 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ээлжит хурал дээр ЭОТ ХХК-ийн зүгээс буюу Монголын талыг төлөөлсөн ТУЗ-ийн гишүүд: *"ОТ ХХК-ийн 2020 оны төсвийг хэлэлцэхдээ арбитрт хандах асуудлаар буюу татварын маргааныг шийдвэрлэх зорилгоор төсөвлөсөн арбитрын үйл ажиллагааны зөвлөх үйлчилгээний зардал 10.8 сая ам.долларыг батлахгүй байх"* "Удирдамж" чиглэлтэй оролцсон. Тухайн асуудлыг хэлэлцэхэд Монголын талын ТУЗ-ийн гишүүд эсэргүүцсэн байр суурийг илэрхийлж, батлах санал хураалтад татгалзсан бөгөөд бусад хувьцаа эзэмшигчдийн төлөөллийн дэмжсэнээр дийлэнх олонхын саналаар баталж байв. Үүнд:
 - 2020 оны ажлын даалгаврууд буюу хамааралтай этгээдээс авах ажил үйлчилгээ, мөн татварын маргааныг шийдвэрлүүлэх арбитрын үйл ажиллагааны зардал дээр талууд санал нийлээгүй;
 - 2020 онд хамааралтай этгээдээс авах ажил үйлчилгээ, мөн татварын маргааныг шийдвэрлүүлэх арбитрын зардлыг батлахыг зөвшөөрөөгүй;
 - Хамааралтай талаас авах ажил үйлчилгээ болон арбитрын зардлын талаарх тогтоолтой холбогдуулж, Монголын талын төлөөлөл дэмжээгүй гэдгийг онцлон тэмдэглүүлж;
 - 2020 оны ажлын даалгаврууд (SOW) буюу хамааралтай талаас авах ажил үйлчилгээний болон арбитрын үйл ажиллагааны төсвийг батлах тухай тогтоолыг Монголын талын гишүүд татгалзаж, бусад бусад гишүүд дэмжсэнээр дийлэнх олонхын саналаар батлагдсан байдаг.
11. 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр ОТ ХХК-ийн Гүйцэтгэх захирлаас 505/1 тоот албан бичгээр ОТ ХХК-ийн ТУЗ-ийн гишүүдэд "ТЕГ-ын Шийтгэлийн хуудас болон Мэргэжлийн хяналтын ерөнхий газар(МХЕГ)-ын албан шаардлагатай холбоотой Маргааныг Лондонгийн Олон Улсын арбитрын шүүхээр шийдвэрлүүлэх тухай мэдэгдэл"-ийг ирүүлсэн. Тус "Мэдэгдэл"-д ОТ ХХК нь ХеОГ-ний маргаан шийдвэрлэх зохицуулалтын дагуу "Шийтгэлийн хуудас болон холбогдох асуудалтай холбоотой Маргаан үүссэн тухай мэдэгдэл – Хэлэлцээ хийх хүсэлт хүргүүлэх тухай мэдэгдэл"-ийг 2018 оны 03 дугаар сард Монгол Улсын Засгийн газар (Сангийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд, БОАЖ-ын сайд)-т хүргүүлж, маргааныг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх хугацаа 2018 оны 06 дугаар сард дууссан талаар тус "Мэдэгдэл"-д дурдаж, ХеОГ-ний дагуу Лондонгийн Олон Улсын арбитрын шүүхэд хандах тухай мэдэгдсэн.
12. Лондонгийн Арбитрын шүүхээс 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдрийн "Арбитрын мэдэгдэл", 2020 оны 11 дүгээр сарын 02-ны өдрийн "Нэхэмжлэлийн мэдүүлэг"-ийг тус тус хүлээн авч тэдгээрт хариу тайлбар өгөх асуудлаар дараах ажлын хэсэг байгуулагдан ажиллаж байна. Үүнд, Монгол Улсын Ерөнхий сайд 2020 оны 3 дугаар сарын 11-ний өдрийн 32 дугаар захирамжаар

Монгол Улсын Засгийн газарт холбогдох арбитрын маргааны хууль зүйн үндэслэлийг судалж, холбогдох тайлбар, нотлох баримтыг гарган нэхэмжлэлийн шаардлагыг няцааж, Засгийн газрын байр суурь, чиглэлийг хамгаалах үүрэг бүхий Ажлын хэсгийг байгуулсан бөгөөд Ерөнхий сайдын 2020 оны 3 дугаар сарын 30-ны өдрийн 42 дугаар захирамжаар нэмэлт, өөрчлөлт оруулж, Ажлын хэсгийн ахлагчаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, дэд ахлагчаар Сангийн яамны Төрийн нарийн бичгийн дарга ажилласан. Энэхүү Ажлын хэсгийг Монгол Улсын Ерөнхий сайдын 2021 оны 2 дугаар сарын 09-ний өдрийн "Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай" 44 дүгээр захирамжаар шинэчлэн байгуулж, Сангийн сайд ажлын хэсгийг ахлан ажиллаж байна. Арбитрын шүүхэд нэхэмжлэлийн хариу тайлбарыг хүлээлгэн өгөх хугацаа 2021 оны 4 дүгээр сарын 30-ны өдрөөр дуусгавар болох талаар Хууль зүй, дотоод хэргийн яамнаас албан бусаар, урьдчилсан байдлаар мэдээлэл өгсөн болно.

Асуулга 3. Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ болон далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөөг байгуулахдаа Монголын талаас албан тушаалын байдал, эрх нөлөөгөө ашиглан өөртөө болон бусдад давуу байдал үүсгэсэн байж болзошгүй асуудлаар Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк мужийн Дээд шүүхэд гаргаад байсан нэхэмжлэлийг сэргээн шалгуулах арга хэмжээг яаралтай авч хэрэгжүүлэх, энэ талаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай

"Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийг нэхэмжлэгч гэж тодорхойлон дурдаж, түүнийг төлөөлж дөрвөн улсын 4 өөр шүүхэд гаргасан нэхэмжлэл, түүний шаардлага, мөн хариуцагчийг тодорхойлсон мэдээллийг олон нийтэд цахим сүлжээнд нээлттэй байгаа эх сурвалжид үндэслэн дараах товч мэдээллийг бэлтгэн, энэ асуулгын хариултад дор дурдсан байдлаар тусгаж байна.

"Нэхэмжлэгч гэж тодорхойлон дурдаж" гэсний учир нь "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийн зүгээс хууль зүйн туслалцаа үзүүлэх чиг үүрэг бүхий аливаа хуулийн этгээдүүд болон иргэнд, түүнчлэн төрийн нэр бүхий бусад байгууллага /прокурор/-д нэхэмжлэл, түүнд дурдсан шаардлагын асуудлаар одоог хүртэл хүсэлт, гомдол гаргаагүй, гаргахаар илэрхийлээгүй⁴ болно.

⁴ 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Microsoft Teams ашиглаж явуулсан шүүхийн сонсголын тэмдэглэлийн 26-28 дахь талд:

"Шүүгч: Barry R. Ostrager

Сонголд оролцсон:

- King & Spalding LLP хуулийн фирмийн өмгөөлөгч James E. Berger;
- Kellnes Herlihy Getty & Friedman LLP хуулийн фирмийн өмгөөлөгч Douglas A. Kellner;
- Gibson, Dunn & Crutcher LLP хуулийн фирмийн өмгөөлөгч Lee R. Crain

...Шүүгч: Монгол улс нэхэмжлэгч гэдгийг би яаж мэдэх вэ?

Berger: Би энэ талаар өмнө нь хэлэх хэрэгтэй байж. Ингээгүйд намайг өршөөгөөрэй. Би шүүхийн харьяаллын талаар асуусан Шүүгчийн асуултад хариулахыг хүссэн юм.

Бидэнд прокурорын байгууллага нь Улсын нэрийн өмнөөс тусгайлсан итгэмжлэл шаардагдахгүйгээр нэхэмжлэл гаргах эрхтэй байдаг талаар Монгол Улсын Ерөнхий прокурорын орлогч прокурорын мэдүүлэг байгаа.

...Прокурорын байгууллага нь манай хуулийн фирмийг авсан ба энэхүү нэхэмжлэлийг гаргах талаар зааварчилгаа өгсөн юм.

...Элчин сайдын яам болон шударга ёсны яамны хүмүүсийн зааварчилгаагаар ажиллаж байгаа.

...Бидэнд Улсын нотлох баримтыг өгсөн. Бидэнд тэр нь хангалттай байсан тул үүний дагуу нэхэмжлэл гаргасан юм."

гэжээ. Энэ талаар <https://iapps.courts.state.ny.us/nyscef/ViewDocument?docindex=n6FdkZmmbHPibmI3FCp8LA==> дэлгэрүүлэн харах боломжтой.

Олон нийтэд цахим сүлжээнд нээлттэй байгаа эх сурвалжуудад дараах мэдээллүүд байршжээ. Үүнд:

АНУ-ын Нью-Йорк мужийн дээд шүүхэд гаргасан нэхэмжлэл⁵-ийн талаар:

Нэхэмжлэгчийн тухай:

2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийг нэхэмжлэгчээр тодорхойлж, тэдгээрийг төлөөлөн Нийслэлийн Прокурорын газраас Кинг & Спалдинг хуулийн фирмээр дамжуулан нэхэмжлэл гаргажээ.

Хариуцагчийн тухай:

Нэхэмжлэлд Сүхбаатарын Батболд, Батболдын Баттүшиг нарыг төлөөлж GIBSON, DUNN & CRUTHER, LLP хуулийн фирм, Cheong Choo Young, Kim Hak Seon, Balooas Inc., Balooas Limited, Lovitas, Inc., Lovitas Limited, Glowassets Limited нарыг төлөөлж KELLNER HERLIHY GETTY & FRIEDMAN LLP хуулийн фирм, Чимэддоржийн Ганзориг, Уламбаярын Туул, Очирбатын Нямдалай, Kim Yoonjung, Lee Yu Jeong, Rhee Byung Wook, Kang Eun Joo нар (11 иргэн, 5 хуулийн этгээд)-ыг хариуцагчаар тодорхойлж, дурджээ.

Нэхэмжлэлийн шаардлагын тухай:

Нэхэмжлэлд хариуцагч нар нь тус нутаг дэвсгэрт байгаа хөрөнгөө нуун дарагдуулах, нууцлах гэсэн нэгдсэн үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон тул тэдгээрийн Монгол Улсын хамгийн үнэ цэнтэй ашигт малтмалын 2 орд болох Эрдэнэт үйлдвэр /зэсийн/, Оюу Толгойн /зэс, алтны/ нөөцтэй холбоотой хийсэн хууль бус луйврын үйлдлийн улмаас учирсан 713,575,000,000 төгрөг буюу ойролцоогоор 250 сая ам.долларын хохирлыг гаргуулах, энэ зорилгоор:

(a) Хариуцагчдын Нью Йоркод эзэмшиж байгаа Хөрөнгө, Үл Хөдлөх хөрөнгийн эзэмшигч Ловитас Инк болон Балоас Инк компанийн хувьцаа зэрэг бусад хөрөнгийг битүүмжлэх эрхийг олгох битүүмжлэл тавих шийдвэр гаргах;

(b) Хөрөнгийн төлбөрийг төлж Нью Йоркийн Банкны дансанд оруулах Нэхэмжлэгчдийн эзэмшдэг хөрөнгийг шилжүүлэх гэсэн Хариуцагчдын үйлдлийг хууль бус гэж зарлах, болон/эсхүл Хариуцагчдаас нөхөн төлбөр болон/эсхүл шүүх хурлаас тодорхойлох үнийн дүнгийн хэмжээтэй хохирлыг төлүүлэх шийдвэр гаргах;

(c) Үл хөдлөх хөрөнгө, Нью Йоркийн Ловитас Инк. болон Балоас Инк. Компаниудын хувьцаа болон Нью Йорк дахь Банкны данснуудыг Нэхэмжлэгчдийн эсрэг үйлдсэн хууль бус ажиллагаа болон луйвраас олсон орлого гэж үзэх шийдвэр гаргах;

(d) Нэхэмжлэгчдийн шаардлагыг хангах зохих бусад нэмэлт шийдвэр зэргийг нэхэмжлэлийн шаардлага болгожээ.

⁵ <https://iapps.courts.state.ny.us/nyscef/ViewDocument?docIndex=SgpyvhXJe4HvEAlpm0LuNg==>

Уг асуудалд холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатараас 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр дээр дурдагдсан "Кинг энд Спалдинг" хуулийн фирмд хандаж "Маргаантай асуудлын талаар" 1/475 дугаартай албан бичгийг илгээжээ. Тус албан бичгийн 4 дэх догол мөрөнд "Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк мужийн Дээд шүүхэд гаргаад байсан нэхэмжлэлийн шаардлагыг хэвээр хадгалж, шүүхийн үйл явцыг сэргээх хүсэлтийг Монгол Улсын Ерөнхий прокурорын газарт уламжилж буй талаар Та бүхэнд мэдэгдье. Нэхэмжлэлийн шаардлагыг зохих журмын дагуу аливаа өөрчлөлтгүй сэргээж, төлөвлөж байсан шүүх хуралдааныг хуралдуулах хүсэлтийг зохих журмын дагуу шүүхэд гаргана уу." гэжээ.

Асуулга 4. Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ болон далд уурхайн бүтээн байгуулалтын санхүүжилтийн төлөвлөгөөтэй холбоотой асуудлаар Америкийн Нэгдсэн Улсын Нью-Йорк мужийн Дээд шүүхэд товлогдоод байсан хурлыг хэний санаачилгаар цуцалсан талаар

Бидэнд мэдэгдэж, олдсон, олон нийтэд цахим сүлжээнд нээлттэй байгаа эх сурвалжуудад асуулгад холбогдох дараах мэдээллүүд байршжээ. Үүнд:

2020 оны 11 дүгээр сарын 23-ны өдөр Сүхбаатарын Батболд, Батболдын Баттүшиг, Cheong Choo Young, Kim Hak Seon, Baloas Inc., Baloas Limited, Lovitas Inc., Lovitas Limited, Glowassets Limited, Чимэддоржийн Ганзориг, Уламбаярын Туул, Очирбатын Нямдалай, Kim Yoonjung, Lee Yu Jeong, Rhee Byung Wook, Kang Eun Joo нар (11 иргэн, 5 хуулийн этгээд)-ыг хариуцагчаар тодорхойлж, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК-ийг нэхэмжлэгчээр тодорхойлж, Кинг & Спалдинг хуулийн фирмээр дамжуулан **АНУ-ын Нью-Йорк мужийн дээд шүүхэд хандаж гаргасан** нэхэмжлэлээсээ Кинг & Спалдинг хуулийн фирм өөрөө татгалзсан тухай эх сурвалжид дурджээ.

Тухайлбал,

- 2020 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Кинг & Спалдинг хуулийн фирм нь "CPLR 3217 (a) заалтад заасны дагуу нэхэмжлэгч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрдэнэт ТӨҮГ, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь дор гарын үсэг зурсан өмгөөлөгчөөрөө дамжуулан хариуцагч Сүхбаатарын Батболд, Чимэддоржийн Ганзориг, Уламбаярын Туул, Очирбатын Нямдалай, Ким Ёнжун, Ли Юу Жеон, Канг Юн Жу болон Батболдын Баттүшиг нарын эсрэг гаргасан нэхэмжлэлээ аливаа гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүйн зэрэгцээ ямар нэг зардал учруулалгүйгээр бүхэлд нь татан авч буйгаа ҮҮГЭЭР МЭДЭГДЭЖ БАЙНА." гэж;
- 2021 оны 1 дүгээр сарын 19-ний өдөр Кинг & Спалдинг хуулийн фирм нь "CPLR 3217 (a) заалт болон 2020 оны 12-р сарын 22-ны өдрийн шүүгчид гаргасан хүсэлт (Dkt. No. 195)-д заасны дагуу нэхэмжлэгч Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, Эрдэнэт ТӨҮГ, "Эрдэнэс Оюу Толгой" ХХК нь дор гарын үсэг зурсан өмгөөлөгчөөрөө дамжуулан хариуцагч Чеон Чүү Ёон, Ким Хак Сеон, Рий Бён Вүү, Baloas Inc., Baloas Limited, Lovitas. Inc., Lovitas Limited болон Glowassets Limited нарын эсрэг гаргасан нэхэмжлэлээ бүхэлд нь аливаа гуравдагч этгээдийн эрхийг хөндөхгүйн зэрэгцээ ямар нэг зардал учруулалгүйгээр татан авч буйгаа ҮҮГЭЭР МЭДЭГДЭЖ БАЙНА." гэж тус тус нэхэмжлэлээсээ татгалзжээ.

Энэхүү асуудалтай холбогдуулан Хууль зүй, дотоод хэргийн сайд Х.Нямбаатараас 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр "Кинг энд Спалдинг" хуулийн фирмд хандаж "Нэхэмжлэлийн шаардлагыг зохих журмын дагуу аливаа өөрчлөлтгүй сэргээж, төлөвлөж байсан шүүх хуралдааныг хуралдуулах хүсэлтийг зохих журмын дагуу шүүхэд гаргах" тухай 1/475 дугаартай албан бичгийг хүргэсэн талаар энэхүү асуулгын хариулт мэдээллийн "Асуулга 3"-т дурдсан болно.

-----oO-----